

Дундговь аймгийн Засаг даргын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдтай 2023 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 18

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ


Цахим хөгжил, харилцаа холбооны сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 22 үүргийг хүлээж, үүргийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласнаар хагас бүтэн жилээр арга хэмжээний хэрэгжилт 99.8 хувьтай байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Цахим засаглалын бодлогыг “Цахим аймаг-Ухаалаг Дундговь” цогц арга хэмжээний хүрээнд аймгийн болон сумдын цахим хуудсыг шинэчлэн мэдээллийн ил тод байдлын 98 шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг цахим хуудсанд байршуулж 12 сарын 10 ны байдлаар 98.9 хувь болсон байна.




**SHILEN.GOV.MN цахим платформын үнэлгээ 47,3 хувиас 98.97 хувь
болж өссөн.**



Иргэд цахим хуудаснаас мэдээлэл авахаас гадна QR код уншуулах, ухаалаг дэлгэц ашиглан мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.





Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны facebook хуудсаар дамжуулан иргэдэд 98 төрийн мэдээллийг хүргж байна.

Доорх холбоосоор орж мэдээлэлтэй танилцана уу.

<https://www.facebook.com/dundgobi7059106/posts/pfbid0qETfcNNeMcEuuzvqhQCQ6AiL3wD6RuDBrUiAJ6a9zmE78GMGqLMheebqG9ndp9hi>

Орон нутгийн төрийн цахим үйлчилгээний хэлтэс 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, ХУРДАН хоёр цэгийг шинээр байгуулсан.



Иргэдэд цахим үйлчилгээ үзүүлсэн тоо - 6100

Цахим ур чадварын сургалтын тоо - 65

Хамрагдсан иргэдийн тоо - 5129






“Цахим үндэстэн-E-Nation” зорилтын хүрээнд мэдээллийн технологийн чиг үүрэг бүхий албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах замаар иргэд, төрийн албан хаагчдын цахим ур чадвар /тоон бичиг үсэг-Digital literacy/-ийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөн нийт 65 удаагийн сургалтыг зохион байгуулж танхимаар 1575, цахимаар 1354 нийт 2929 иргэн, төрийн албан хаагчдад цахим ур чадварын сургалтыг зохион байгууллаа.




Сургалт-65 удаа 5129 иргэн
Танхимаар -1575
Цахимаар - 1354
Алсын хараа 2050 - 2200




Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хөдөөгийн сэргэлт” ажлын хүрээнд хүрээнд Дундговь аймгийн талаарх [/huduu.mn/](http://huduu.mn/) цахим хуудсыг хөгжүүлж, “Нээлттэй

Дундговь” видео контентуудыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлж, цахим хуудас бусад мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллаж байна. Орон нутгийн онцлох ажлуудын талаар видео мэдээллүүдийг бэлтгэн Монголын үндэсний телевиз, Өлзийт, Малчин телевизүүдтэй гэрээ байгуулан олон нийтэд хүргэж байна. Төрийн албан хаагчийн цахим ур чадварыг дээшлүүлэх 8 контентыг бэлтгэн төрийн байгууллагуудын дотоод удирдлагын ERP системээр хүргүүлсэн. 2023 онд нийтдээ 35 контент үйлдвэрлэл, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн иргэдэд хүргэж ажилласан.



Тоон гарын үсэгтэй болох ажлыг эрчимжүүлэх үүднээс сургалтуудыг зохион байгуулж нийт 58 албан тушаалтнууд албан тушаалын тоон гарын үсэгтэй болж албан бичиг цахимаар боловсруулах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр тоон гарын үсгээр баталгаажсан цахим албан бичиг солилцож байна.



Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 19271 иргэн буюу 60.1 хувьд олгоод байна. Өмнөх онтой харьцуулахад тоон гарын үсэг олголт 22.1 хувиар ахисан үзүүлэлттэй байна.

Иргэдийн тоон гарын үсгийн олголт




Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны бүх байгууллага дотоод удирдлагын erp.e-mongolia.mn цахим системд холбогдож, үйл ажиллагаагаа тус системээр явуулж байна. Одоогийн байдлаар 87 байгууллагын 2677 төрийн албан хаагч тус системд бүртгэлтэй байгаагаас 2032 албан хаагч тогтмол ашиглаж байна.

Албан бичиг: солилцроны дундын систем: үр дүн

Бүх сумдын Засаг даргын Тамын газар Албан бичиг солилцроны дундын системд холбогдсон.

Аймгийн төвд Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” гурван цэгийг шинээр байгуулж, цахим үйлчилгээний операторын системийн шинэчлэн 531 төрлийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллаж байна.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний Цахим хөгжил, харилцаа, холбооны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 99.8 хувь буюу “Тодорхой үр дүнд” хүрсэн гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийн зарцуулсан байна.

Цахим хөгжилтэй холбоотой арга хэмжээнүүдийг аймгийн бодлогын баримт бичгүүд болон бүх шатны төлөвлөлтөд тусган хэрэгжүүлснээс гадна мэдээлэл технологийн инженерийн ажлын ур чадвар, хариуцлага ихээхэн нөлөөлсөн гэж үзэж байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Төрийн захиргааны удирдлагын хэлтэст:

1. Гэрээнд тусгагдсан үүргийн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө суурь түвшин, хүрэх түвшин бодитой судалгаанд үндэслэн тодорхойлох

2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг оны эхэнд unelgee.gov.mn төрийн мэдээллийн цахим системд оруулж баталгаажуулах

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга

Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн

дарга

Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Одончимэг